



АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД: ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН БҮРТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2016.10.10 Ашигт малтмалын тухай болон Татварын ерөнхий хуулиуд, мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу ашигт малтмалын хайгуул ба ашиглалтын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх бүхий хуулийн этгээд нь өөрийн эцсийн өмчлөгч/ эзэмшигчийн мэдээллийг 2018 оны 6 дугаар сарын 1-ээс өмнө Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар (ХЭУБГ) болон харьяа татварын байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээв.

Мөн өмчлөгч/эзэмшигчийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг харьяа татварын байгууллагад 10 хоногийн дотор, ХЭУБГ-т ажлын 15 өдрийн дотор бүртгүүлж, холбогдох албан татвар төлнө.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.11, 16.14-т заасан аргачлалын дагуу холбогдох татварыг тайлагнаагүй, эсхүл үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан, эсхүл ХЭУБГ-т үнэн зөв мэдээлээгүй бол тусгай зөвшөөрлийг цуцална.

2017.03.26 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн шинэчилсэн найруулгаар орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу “эцсийн өмчлөгч”-ийн тодорхойлолтыг шинэчлэн баталсан нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байна.

2019.03.22 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт орсноор бүх хуулийн этгээд 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн эцсийн өмчлөгчийн мэдээллээ ХЭУБГ-т бүртгүүлэх үүрэг хүлээсэн.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт орсноор ХЭУБГ-т эцсийн өмчлөгчийн мэдээллээ үнэн зөв мэдээлээгүй хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах заалтыг хассан.

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ БАЙДЛААР

2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 3261 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг 2088 компани эзэмшиж байна. Эдгээрийн 1145 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл, 943 нь хайгуулын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байна (график 1-ийг харна уу). Тусгай зөвшөөрөл эзэмшигч 2088 компани нь 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Татварын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ 2018 оны 6 дугаар сарын 1-ний дотор улсын бүртгэлийн болон харьяа татварын байгууллагад нөхөн бүртгүүлэх ёстой байв.

Дээрх үүргийн хэрэгжилтийг 2019 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар авч үзэхэд ХЭУБГ-т нийт 436 аж ахуйн нэгж, тэдгээрийн эцсийн өмчлөгч 754 этгээд, Татварын ерөнхий газар (ТЕГ)-т нийт 547 аж ахуйн нэгж, тэдгээрийн эцсийн эзэмшигч 668 этгээдийн мэдээлэл бүртгэгджээ (график 2-ыг харна уу).

ГРАФИК 1.

ХҮЧИН ТӨГӨЛДӨР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН ЭЗЭМШИГЧ КОМПАНИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ





ГРАФИК 2.

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ/ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЛЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ (2019 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар)



Дээрх графикт үзүүлсэн ТЕГ-т эцсийн эзэмшигчийн мэдээллээ бүртгүүлсэн 547 компаниас 341 нь ХЭУБГ-т бүртгүүлээгүй байгаа бол эсрэгээрээ ХЭУБГ-т бүртгүүлсэн 436 компаниас 230 нь ТЕГ-т мэдээллээ бүртгүүлээгүй байгаа юм. Энэхүү тоон үзүүлэлтийг график 3, 4-т үзүүлэв.

ГРАФИК 3.

ТЕГ-Т БҮРТГҮҮЛСЭН ААН-ИЙН ТОО





ГРАФИК 4.

УБЕГ-Т БҮРТГҮҮЛСЭН ААН-ИЙН ТОО



Эдгээр мэдээллийг нэгтгэн үзвэл, дээрх хоёр байгууллагад давхардаагүй тоогоор нийт 777 (ХЭУБГ-т бүртгүүлсэн 230, ТЕГ-т бүртгүүлсэн 341, аль алинд бүртгүүлсэн 206) аж ахуйн нэгж эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ бүртгүүлсэн нь нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн 37 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 2088 компанийн 63 хувь буюу 1322 нь эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ огт бүртгүүлээгүй байна.

Эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ бүртгүүлсэн компаниудаас 4 компанийн мэдээлэл нь иж бүрдэл дутуу буюу эцсийн эзэмшигчийн тоо тодорхойгүй байна. Мөн 11 компани тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэлээс хасагдсан нь тусгай зөвшөөрөл цуцлагдсан, эсхүл бусдад шилжүүлснээс болсон байх магадлалтай.


ГРАФИК 5.

ТЕГ БОЛОН ХЭУБГ-Т ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ/ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЛЭЭ ОГТ БҮРТГҮҮЛЭЭГҮЙ КОМПАНИЙН ТОО (2019 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар)



ГРАФИК 6.


ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ/ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЛЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО (Тусгай зөвшөөрлийн төрлөөр)



Эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ бүртгүүлсэн дээрх 777 аж ахуйн нэгжийг эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн төрлөөр нь ангилж үзвэл 314 нь зөвхөн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй, 452 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байна. Харин 11 хуулийн этгээд эцсийн өмчлөгч/эзэмшигчийн бүртгэл хийгдсэний тусгай зөвшөөрлийн бүртгэлээс хасагджээ. Тэрчлэн газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжүүд эцсийн өмчлөгч/эзэмшигчийн бүртгэлд огт хамрагдаагүй байна.

ГРАФИК 7.

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ/ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНААС ӨМНӨ БОЛОН ХОЦОРЧ БҮРТГҮҮЛСЭН, БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛДЭЭ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН КОМПАНИЙН ТОО



Хуульд заасан хугацаагаар авч үзвэл, 2018 оны 6-р сарын 1-ний өдрөөс хойш ХЭУБГ-т нэг ч аж ахуйн нэгж эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ шинээр нэмж бүртгүүлээгүй бол ТЕГ-т 58 аж ахуйн нэгж нөхөн бүртгүүлжээ. Харин анх бүртгүүлснээсээ хойш 47 аж ахуйн нэгж ХЭУБГ-т хандаж мэдээллээ өөрчилсөн бол ТЕГ-т ердөө 2 компани эцсийн эзэмшигчийн мэдээлэлд орсон өөрчлөлтөө бүртгүүлжээ (график 7-г харна уу).

2019 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 2088 хуулийн этгээд ашигт малтмалын хайгуул, ашиглалтын 3261 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дөнгөж 20.8 хувь буюу 436 аж ахуйн нэгж нь ХЭУБГ-т эцсийн өмчлөгчийн бүртгэлээ хийлгэжээ. Харин татварын байгууллагад 547 хуулийн этгээд эцсийн эзэмшигчийн мэдээллээ бүртгүүлсэн нь тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт компанийн 26 хувь болж байна.

Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компани нь хуулийн дагуу эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллийг дээрх хоёр байгууллагад аль алинд нь бүртгүүлэх ёстой боловч ийнхүү давхар бүртгүүлсэн компани ердөө 206 байна. Энэхүү 206 компанийг давхардуулалгүй тооцвол дээрх хоёр байгууллагад эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ бүртгүүлсэн 777 компани байгаа нь нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн 37 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 2088 компаниас 63 хувь нь эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ холбогдох төрийн байгууллагад огт мэдээлээгүй байхад Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.11-д заасны дагуу хариуцлагын арга хэмжээ авагдаагүй байна.

Тэрчлэн ХЭУБГ, ТЕГ-т эцсийн өмчлөгч/эзэмшигчийн мэдээллээ бүртгүүлсэн 777 (давхардаагүй тоогоор) аж ахуйн нэгжээс 4 компанийн мэдээлэл иж бүрдэл дутуу буюу эцсийн өмчлөгч/эзэмшигч хувь хүний тоо тодорхойгүй, 11 компани тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэлээс хасагдсан (цуцлагдсан эсвэл шилжүүлсэн байх магадлалтай) байв.

ХЭУБГ-т 46 хуулийн этгээд эцсийн өмчлөгчийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг бүртгүүлсэн

бол татварын байгууллагад зөвхөн 2 хуулийн этгээд өөрчлөлтөө бүртгүүлжээ. Үүнээс харахад өмчлөгч өөрчлөгдөх замаар тусгай зөвшөөрөл шилжүүлэхэд хуульд заасны дагуу холбогдох татвар төлөх хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Гэтэл ийнхүү татвар төлөх үүргээ хэрэгжүүлээгүй хуулийн этгээдэд Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.10-т заасны дагуу хариуцлага тооцсон тухай мэдээлэл байхгүй байна.

2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хэрэгжсэн эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх шаардлага 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойш бараг зогсож, татварын байгууллагад зөвхөн 17 хуулийн этгээд нөхөж бүртгүүлсэн нь хуулийг сурталчлах, хариуцлага тооцох замаар хэрэгжилтийг эрчимжүүлэх ажил тулгамдаж байгааг харуулж байна. Эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгүүлсэн хуулийн этгээдийн 314 нь зөвхөн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй, 452 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байв. Харин газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгж бүртгэлд огт хамрагдаагүй байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон татварын байгууллага аль алинд нь мэдээллээ өгсөн 206 компани байгаа боловч эдгээрийн 83 нь дээрх хоёр байгууллагад эзэмшигчийн тоогоо зөрүүтэй мэдээлжээ. Энэ нь мэдээллийн үнэн зөв байдлыг магадлах ажиллагаа хийгдэхгүй байгааг харуулахын хамт төрийн байгууллагууд мэдээллээ солилцох замаар харилцан хяналт тавих шаардлагатай байгааг харуулж байна.

Ийнхүү эцсийн өмчлөгчийн мэдээлэл, өөрчлөлтөө бүртгүүлээгүй хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах үүргээ хэрэгжүүлээгүй буруутай төрийн байгууллага, албан тушаалтанд мөн хариуцлага тооцоогүй байна.